БАТЛАВ:
“ЭРДЭНЭТ ҮЙЛДВЭР” ТӨҮГ-ЫН
ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР
.....Т.БАТМӨНХ
2025 оны 03 сарын 26-өдөр

МОЛИБДЕНЫ БАЯЖМАЛЫН ТЭЭВЭР ЗУУЧИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ТЕХНИКИЙН ДААЛГАВАР

ТАНИЛЦСАН:

ЗАХИРГАА, УДИРДЛАГА, САНХҮҮГИЙН ГАЗРЫН ДАРГА Д.БАЯРБАТ

ХЯНАСАН:

ГАДААД ХАРИЛЦАА, ЭКСПОРТЫН ХЭЛТСИЙН ДАРГА Я.ПҮРВЭЭ

БОЛОВСРУУЛСАН:

ГАДААД ХАРИЛЦАА, ЭКСПОРТЫН ХЭЛТСИЙН ТЭРГҮҮЛЭХ МЭРГЭЖИЛТЭН Б.ЦЭЛМЭГ

Орхон аймаг

2025 он

1. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

1.1.	Ажлын нэр	Молибдены баяжмалын экспортын тээвэр зуучийн үйлчилгээ.
1.2.	Ажил гүйцэтгэх үндэслэл:	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 10 дахь заалт, "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөө зэргийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд хийгдэнэ.
1.3.	Ажлын зорилго	Захиалагчийн хүсэлтийн дагуу Монгол Улс, БНХАУ болон гуравдагч оронд молибдены баяжмалыг чингэлэгт ачиж төмөр замаар тээвэрлэх, зуучлах ажлыг зохион байгуулах.
1.4.	Гүйцэтгэх ажлын хамрах хүрээ	Талуудын үйл ажиллагааг Олон Улсын төмөр замын ачаа тээврийн /ОУТЗАТ/ дүрэм, Засгийн газар хоорондын болон хилийн төмөр замын хэлэлцээр, Монгол Улсын авто болон төмөр замын тээврийн аюулгүй байдлын тухай хууль, тухайн тээврийн хэрэгслээр ачаа тээвэрлэхэд мөрдөгдөх журам, олон улсын тээвэрт олон улсын Ачааны Харилцааны хэлэлцээр, мөн тэдгээр улсуудын нутаг дэвсгэрт үйлчилж буй үндэсний тээврийн эрх зүйн дагуу зохицуулна.
1.5.	Гүйцэтгэх ажлын иж бүрдэл	Гүйцэтгэгч нь "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын 2025 оны экспортын төлөвлөгөөнд тусгагдсанаар жилд 6,240 тн молибдены баяжмалыг ачих чингэлгээр тасралтгүй хангах, ачаатай чингэлгийг БНХАУ-ын Эрээн өртөөнд хүргэх ажлыг хийж гүйцэтгэнэ. Худалдан авагчтай зөвшилцсөний үндсэн дээр Эрээн өртөөнөөс цааш Худалдан авагчийн хүлээн авахыг хүссэн БНХАУ болон гуравдагч улсын өртөө, боомт хүртэл ачааг тээвэрлэх ажлыг хийж гүйцэтгэнэ. Шаардлагатай тохиолдолд нийтээр амрах баяр, ёслолын өдрүүд болон орой, шөнийн цагаар хөндлөнгийн хяналт хийгдэж болно.

Гүйцэтгэгч нь тэвэр зуучийн үйлчилгээ үзүүлэхдээ Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй холбогдох хууль тогтоомж, дүрэм журмыг чанд баримтлан ажиллана.

Захиалагчийн баталж өгсөн ачилтын даалгаварт заасан тоо хэмжээний ажлыг хийж гүйцэтгэнэ.

Захиалагчийн ачааг гэрээнд заасан цэгт хүргэх хүртэл ачааны бүрэн бүтэн байдал, аюулгүй байдлыг бүрэн хариуцна.
Захиалагч талын инженер техникийн болон хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, байгаль орчны ажилтнуудын холбогдох дүрэм журамд нийцүүлэн тавьсан шаардлагыг биелүүлж ажиллана.
Гүйцэтгэгч тал нь гүйцэтгэсэн гэрээт ажлын хэмжээг сар бүр холбогдох бичиг баримтад үндэслэн Захиалагч талд нэгтгэн ирүүлнэ.

2. ТАВИГДАХ ШААРДЛАГА

2.1. Чадвар

Гүйцэтгэгчийн чадварын үзүүлэлтүүд нь энэхүү ажлыг гүйцэтгэх гол шалгуур ба Захиалагч нь гүйцэтгэгчийн чадварыг нотлох нэмэлт мэдээллүүд шаардана. Үүнд:

I. Төмөр замын тээврийн аюулгүй байдалтай холбоотой үйл ажиллагаа эрхлэх гэрчилгээтэй байх, нотлохуйц албан байгууллагын гэрчилгээг хавсаргана;
II. Олон улсын тээвэр зуучлал, тээвэр ложистикийн болон чингэлэг тээврийн үйлчилгээний чиглэлээр 5-аас доошгүй жил тогтвортой үйл ажиллагаа явуулсан байх;
III. Захиалагчийн даалгавраар чингэлэг хангалт болон ачаа тээвэр-зуучийн үйлчилгээг үзүүлэх. Экспортын чингэлэг хангалтыг найдвартай хангах чадвартай байх, чингэлэг эзэмшигч талуудтай хийсэн гэрээтэй байх;
IV. Сүүлийн 3 жилд уул уурхайн бүтээгдэхүүнийг БНХАУ, өөр бусад гуравдагч улсад төмөр замаар болон далайн

		тээврээр тээвэрлэхэд тээвэр зуучийн үйлчилгээ үзүүлж байсан туршлагатай байх, холбогдох нотлох баримт, хамтран ажилласан байгууллагын тодорхойлолт хавсаргах;
	V.	Ачаа барааг заасан хугацаанд тээвэрлэх, тээврийн үйл ажиллагаатай холбоотой мэдээллээр хангах, чингэлэг хангалтыг хугацаандаа хийх, тээвэрлэлтийг саадгүй зохион байгуулах туршлагатай, чадвартай байх. Экспортын чингэлэг тээвэрлэлтийн сүүлийн 3 жилийн дундаж хэмжээ жил тутамд 200 х 20 футийн чингэлгээс дээш байх;
	VI.	Санхүүгийн чадамжтай, сүүлийн 3 жилийн дундаж тээвэр зуучийн үйлчилгээний борлуулалтын орлогын хэмжээ 1.2 тэрбум төгрөгөөс багагүй, ашигтай ажилласан татвар төлөгч байх;
	VII.	Эрсдэл даах чадамжтай байх. Байгууллагын хуримтлагдсан ашгаас тодорхой хэмжээгээр эрсдэлийн санг байгуулсан байх;
2.2. Техникийн шаардлага	I.	Экспортын чингэлэг хангалт болон тээвэрлэлтэд 5-аас доошгүй жилийн туршлагатай, хүний нөөцтэй байх;
	II.	Эрдэнэт хотод тээвэрлэлт хариуцсан суурин төлөөлөгч томилон ажиллуулах. Төлөөлөгчтэй бол давуу тал болно;
	III.	Захиалагчийн тусгайлан бичгээр өгсөн даалгаврын дагуу түүний зардлаар гаалийн бүрдүүлэлт /гаалийн горим болон нийлүүлэлтийн гэрээний дагуу/, төмөр замаар тээвэрлэж буй ачааг ачих-буулгах ажил, мөн түүнчлэн хоосон чингэлэг хадгалах терминалуудтай хамтран ажиллах гэрээтэй байх, Захиалагчийн өртөө хүртэлх тээвэрлэлтийн явцад ачааны бүрэн бүтэн байдлыг хангах;

2.3.	Тээвэрлэлтийн шаардлага	I. Захиалагчийн захиалгын үндсэн дээр захиалсан ачааг тээвэрлэлтийн оновчтой схемээр хэрэгжүүлж тээвэрлэлтийн бүх оролцогч нарт хүргэх. “Улаанбаатар төмөр зам” ХНН-тэй хамтран ажиллах гэрээтэй байх; II. ~2.5 тонны багтаамжтай баяжмалын уутанд савласан молибдены баяжмалыг 20 футийн стандарт (ISO 1496-1:2013) чингэлэгт ачиж төмөр замаар тээвэрлэх; III. Чингэлэгт ачсан молибдены баяжмалыг БНХАУ-ын Эрээн өртөө хүргэхээс гадна Эрээн өртөөнөөс цааш худалдан авагчийн нэрлэсэн улс, хот, өртөө, боомт, агуулах хүртэл ачааг бүрэн бүтэн тээвэрлэж, хүлээлгэж өгөх, чингэлэг эзэмшигч талуудтай хийсэн гэрээтэй байх. Чингэлэг тээвэрлэлтийн талаар БНХАУ-ын тээвэр зуучийн компанитай хамтран ажиллах гэрээтэй байх. IV. Тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцогч нартай ачааны тээвэрлэлтийн технологийг зөвшилцөх. V. Захиалагчид ачааны тээвэрлэлтийн нөхцөлийг мэдэгдэх ба тээвэрлэлтийн бичиг баримтыг гарган хүргүүлэх.

3. АЖЛЫН ТӨРӨЛ

А. Тээвэрлэлтийн төлөв.

Үзүүлэлт	Хэмжих нэгж
Төмөр зам	
1. “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын Тээвэр ложистикийн төвийн салбар замд ачилтад шаардлагатай хоосон чингэлгийг захиалгын дагуу бэлтгэх:	
А. Чингэлэг тээвэрлэлт:	
Ердийн хоосон чингэлэг	
20тн	тн
Б. “Улаанбаатар төмөр зам” ХНН-ийн Эрдэнэт өртөөнөөс – БНХАУ-ын Эрээн өртөө хүртэл ачаа хүргэх :	
Ердийн ачаатай чингэлэг	
20тн	тн

Б. “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-аас Олон улсын тээвэр зуучлалын компаниар сүүлийн 3 жилд 20 тонны чингэлгээр экспортод ачуулсан молибдены баяжмалын судалгаа.

д/д	Хүлээн авагч улс	Хүрэх өртөө, боомт	Чингэлгийн тоо /20 тонн/	Жин /тонн/
1	БНХАУ	Синьган / Xingang	726	14,142
2	БНХАУ	Эрээн / Erlian	48	932
3	БНСУ	Бусан / Busan	190	3,710
4	Вьетнам	Хай Фонг / Hai Phong	8	155
5	Тайланд	Лаем Чабанг / Laem Chabang	4	78

4. АЖЛЫН ХЯНАЛТ

4.1. Ажлын хяналт

I. Гүйцэтгэгчээс ачаа тээвэрлэлтийн байршил, хөдөлгөөний явцын тухай 24 цагийн дотор мэдээлэх.

II. Захиалагчаас ачаа тээвэрлэх даалгавар ба захиалгыг үнэн зөв цаг тухайд нь гаргаж өгөх, шаардлагатай дагалдах бичиг баримтыг зохих ёсоор бүрдүүлэхийг шаардах.

5. АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ХУГАЦАА

5.1.	Ажил эхлэх	I. Тухайн ажлын хамрах хүрээ, ажлын нийт хэмжээ зэргээс шалтгаалан захиалагч болон гүйцэтгэгч талууд харилцан зөвшилцөж баталсан ажил гүйцэтгэх гэрээ байгуулснаар ажил эхэлнэ. II. Ажил үргэлжлэх хугацааг гэрээнд тусгана.